

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Булган Ундарга ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр live.ard.mn цахим хуудсаар дамжуулан 11:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, хурлын дэг болон хуралд урилгаар оролцож буй ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн удирдлагын алба, Тооллогын комиссын гишүүний төлөөллийг тус тус танилцуулан Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлуудыг танилцуулан тооллогын комиссын даргыг хурлын ирцийг танилцуулахаар урив.

Тооллогын комиссын дарга С.Намжилмаа танилцуулснаар: Булган Ундарга ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 113,212 ширхэг, үүнээс хурал эхлэх үед 102,693 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа нь нийт нэгж эрх эзэмшигчдийн 90.7% болж байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээллэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай Булган Ундарга ХК ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягт мэдэгдэж, хурлыг нээв.

Хэлэлцсэн нь №1:

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;

Танилцуулсан нь:

Крипто Үндэстэн ХХК-ийн менежер Г.Мягмаржав нь компанийхаа талаар товч танилцуулав. Крипто Үндэстэн сан анх 158 хөрөнгө оруулагчтайгаар 2017 онд байгуулагдан, 2.9 тэрбум төгрөгөөр тодорхой хэмжээгээр нь крипто валютуудын багцыг бүрдүүлээд ажилласан. 1 тэрбум тэрбум төгрөгөөр биткойны олборлолтыг хийсэн. Нийтдээ 3 жил гаруй хугацаанд олборлолт хийж 4.2 биткойныг олборлосон үүнээс үйл ажиллагааны зардал зарцуулсан. Хувь тэнцүүлсэн урамшуулал буюу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд 24 биткойныг олгосон. Одоогоор хөрөнгийн багцад 14 орчим криптовалют байдаг. Үүнээс биткойн 2020 оны төгсгөлөөс хойш 2 дахин өссөн, этерум ойролцоогоор 4 дахин өссөн, риплийн хувьд бас 7 дахин өссөн, лайткойн, биткойн каш нэлээн өндөр өсөлтүүдтэй байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Мөн манай багцад чинь ардкойн байгаа багцад үнэлгээгээр бага хувь эзэлж байсан бол одоогоор эзлэх хувь нэмэгдсэн биз дээ?

Г.Мягмаржав: Тийм 2020 оны төгсгөлд

5 төгрөг байсан, тэрнээс хойш 40 дахин өссөн байна. Крипто Үндэстэн маань 2020 оны төгсгөлд хаалтаа хийсэн тухайн үед 143 хөрөнгө оруулагчтайгаар хаалтын хурал маань 90.7 хувийн ирцтэйгээр хийсэн. Компаниас 83 хөрөнгө оруулагч тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулалтаа аваад гарсан бол нийт хувьцаа эзэмшигчид маань 110 хувийн өгөөж авсан. Мөн Крипто Үндэстэнээс гарсан хүмүүстэй ардкойныг нэмж олгосон байгаа. Крипто Үндэстнээс

81 хөрөнгө оруулагч цаашид үргэлжлүүлэн Булган Ундарга ХК-н хувьцааг авахаар шийдсэн байгаа. Булган Ундарга ХК маань хувьцаа 500 төгрөгөөс 7085 төгрөг хүртэл өссөн. Тэгэхээр 1 сарын 27-ны өдрөөс 4 сарын 1-ний өдөр хүртэл арилжааг хаасан. Энэ хугацаандаа Булган Ундарга ХК-ийн хувьцааг сонгосон хүмүүст бүрэн бүтнээр нь хувьцааг нь шилжүүлж чадаагүй байгаа энэ долоо хоногтоо бүх хүмүүстээ хувьцааг шилжүүлээд дуусгахаар ажиллаж байна. Кripto Үндэстэн ХХК-аас Булган Ундарга ХК руу 4.3 тэрбум төгрөгийн крипто валютын багцыг шилжүүлж хөрөнгө оруулалт хийсэн. Үүний дийлэнх нь ардкoйн байсан. Булган Ундарга руу оруулсан багц маань одоо 4 сарын хугацаанд 20.3 тэрбум болтлоо өссөн байна. Булган Ундарга ХК-ийн хувьцааг сонгосон хүмүүс маань хөрөнгөө 4 сарын дотор бас 5 дахин өсгөсөн үүнд гол нөлөө үзүүлсэн зүйл нь ардкoйны өсөлт байгаа. Өмнө нь биткoйн дийлэнх хувийг эзэлдэг байсан бол одоо ардкoйн сангийнхаа дийлэнх хувийг эзэлдэг болчихсон байгаа. Булган Ундарга ХК-аа сонгосон хүмүүсийн хөрөнгө оруулалт хэд дахин өссөн ухаалаг хөрөнгө оруулагч ухаалаг сонголтуудыг хийсэн байх. Тэр хүмүүстээ баяр хүргэе ээ. Одоо тэр ухаалаг, мэргэн, сонголттой хүмүүсийн маань хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэх асуудлууд одоо ингээд цаашаа албан ёсоор эхлээд явна. Одоогоор 81 хөрөнгө оруулагч байна. Үүний дотор хувь хөрөнгө оруулагчид, албан байгууллагууд байгаа юм. Тэр нь голцуу манайхтай холбоотой албан байгууллагууд байна.

Танилцуулсан: ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч, гүйцэтгэх захиралд горилогч Б.Гантиг

Криптовалютийн хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг сан гэдэг нь тухайн сан өөрийн хөрөнгөө криптовалютаар бүрдүүлж хувьцааны үнэлгээгээ тогтоож явдаг нээлттэй санг хэлж байгаа юм. Өдгөө дэлхийд 5 гаруй хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг крипто сан 2021 он гарснаас хойш нээлттэйгээр арилжаалагдаж байна. Монгол улсад энэхүү чиглэлийн санг нээлттэйгээр хэрэглэгчиддээ хүргэх боломж бидэнд бий болоод байна. Энэхүү сангаар дамжуулж, криптовалютад хөрөнгө оруулах боломжгүй хувь хүн ААН-үүд энэхүү сангийн хувьцааг авч оролцох боломж бүрдэж байна гэсэн үг. Энэ боломж нь хэрэглэгчдэд олон давуу талуудыг олгож байна, үүнд: аюулгүй байдал, мэргэжлийн баг хамт олон, эрсдэлийн менежмент гэх мэт давуу талууд байна. Өнөөдөр Булган Ундрага ХК-ийн бодит үнэлгээ өөрөө нэг ширхэг хувьцаа нь 200,000 давсан байгаа нь энэ сан хэр амжилттай, дэлхийн хэмжээний бусад сангуудтай өрсөлдөх бололцоотойг бас харуулж байгаа юм. Бидний үндсэн зорилго бол, криптовалютын салбарт мэргэжлийн түвшинд хөрөнгө оруулалт хийх, арилжаа наймаанд оролцох, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах олон ажлыг эхлүүлэх бодолтой байгаа.

Танилцуулсан нь: Ард Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа

Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчид санал болгосны дагуу Ард Менежмент ҮЦК ХХК нь 2020 оны сүүлээр хөрөнгийн зах зээлээс Булган Ундрага ХК худалдаж авах ажиллагааг зохион байгуулсан. Монголын Хөрөнгийн Биржид 200 орчим хувьцаат компани байдгаас дөчин хоёр хувьцаат компаний үйл ажиллагаа доголдолтой байна. Булган Ундарга ХК нь бидний тавьсан шаардлагад нийцсэн тул 2020 оны 12 сард Ард Бит ХХК худалдаж авч, ажиллуулж байна. Кripto Үндэстэн ХК-ийн 81 хувьцаа эзэмшигч хувьцаа авч эхэлснээр 2021 оны 4 сарын 8-ны өдөр буюу бүртгэлийн өдрөөр 41 хувьцаа эзэмшигчтэй болсон. Жилийн эцсийн байдлаар бол 67 хувийг нь Ард Бит компани, 32.33 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл эзэмшиж байсан. 2020

оны санхүүгийн тайланд Си Эс И аудитын компани аудит хийсэн. 2012 оноос хойш 300 орчим сая төгрөгийн хөрөнгө элэгдээд үнэгүйдсэн байсан тул 2020 онд Ард Бит ХХК нь Булган Ундрага ХК-г худалдан авч хөрөнгүүдийг нь элэгдүүлж, санхүүгийн тайланд тусгасан. Аудитын байгууллагаас компанийн санхүүгийн тайлан дээр аудит хийгээд олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнаса гэсэн дүгнэлт гарсан. Тайланд 2019 оны тайланд 314 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2020 онд үндсэн хөрөнгө элэгдэж хорогдоод дууссан. Харин 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, дахин хөрөнгөжүүлснээр компанийг 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж нэмэгдсэн. Орлогын хувьд 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй компани байсан учраас орлогогүй ажилласан байгаа. Хорогдуулсан хөрөнгүүдээ хорогдуулаад, крипто валютын ханшийн зөрүүний ашиг нэмэгдээд нийт компанийн орлого 175 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

Хэлэлцсэн нь №2:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг томилох;

Танилцуулсан: ТУЗ-д нэр дэвшигчид өөрсдийгөө танилцуулав.

Ердийн гишүүдэд нэр дэвшигчид:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо

Ард Менежмент ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа

И Ай Ти ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Ард Экс ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг

Булган Ундарга ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантиг

Хараат бус гишүүдэд нэр дэвшигчид:

Энхриймаагийн Хасар

Алтангэрэлийн Тулга

Цэрэнгалсангийн Энх-Амгалан нар тус тус нэр дэвшүүлэв.

Хэлэлцсэн нь №3:

Компанийн хаяг байршлыг солих;

Танилцуулсан: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо

Компани нь Булган аймгийн Булган сумд байсан бүртгэлтэй байна. Үүнийг Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Ерөнхий сайд Амарын гудамжинд байрлах Ард Санхүүгийн Нэгдэл байрны хоёрдугаар давхар руу нүүлгэхээр өөрчлөлтийн санал оруулж байна.

Хэлэлцсэн нь №4:

Компанийн дүрмийн шинэчлэгдсэн найруулгыг батлах;

Танилцуулсан нь: Тооллогын комиссын дарга С.Намжилмаа;

Булган Ундарга компани маань өмнө нь суваг усны барилга байгууламж, засвар үйлчилгээ, усны цэг, эрэл хайгуул, худаг шинээр гаргах, засварлах, газар тариалан, мал аж ахуй, дэлгүүрийн жижиглэн худалдаа эрхлэх мөн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхлэх эрхтэй үйл ажиллагааны чиглэлтэй компани байсан. Өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн хурлаар бид компанийн үйл ажиллагааны чиглэлийг гадаад худалдаа болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхлэх эрхтэй байхаар өөрчлөн найруулж байгаа. Хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Компанийн үйл ажиллагааны чиглэлийг гадаад худалдаанаас гадна, крипто валют судалгаа, бизнес зөвлөх үйлчилгээ болон хуулиар хориглоогүй үйл ажиллагааг эрхлэх боломжтой байхаар дүрмийн шинэчилсэн найруулгад оруулах санал гаргаж, бусад хувьцаа эзэмшигчид дэмжлээ. Мөн түрүүн Золбоо танилцуулсанчлан хаягийг өөрчилж байгаа. Мөн дүрмийн шинэчилсэн найруулга буюу дүрэм маань өмнө нь 18 бүлэгтэй дүрэм байсан бол энэ удаагаар дахин найруулаад 12 бүлэгтэй буюу илүү бүтцээ сайжруулсан байгаа. Хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь компанийн нэрийг өөрчилж Дүрмийн шинэчилсэн төсөлд оруулах санал гаргав.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хэдийгээр Булган Ундарга маань гоё утгатай үг боловч эргээд хөрөнгийн зах зээл, крипто арилжаа, чиглэлийн үйл ажиллагаанд илүү тохирох нэр маань Криптон Үндэстэн гэдэг нэр юм болов уу. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид дэмжив.

Санал хураалт явагдаж, дуусав.

Тооллогын комиссын дарга С.Намжилмаа Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Саналын эрхтэй хувьцааны тоо	Саналын эрхтэй хувьцааны тоо/хуралд оролцсон саналын эрхтэй хувьцааны тоо	Саналын эрхтэй хувьцааны тоо	Саналын эрхтэй хувьцааны тоо/хуралд оролцсон саналын эрхтэй хувьцааны тоо	Саналын эрхтэй хувьцааны тоо	Саналын эрхтэй хувьцааны тоо/хуралд оролцсон саналын эрхтэй хувьцааны тоо
1	100,632	97.99%				
3	102,693	100%				
4	102,693	100%				

Хэлэлцэх асуудал 2:

Ердийн гишүүд;

Чулууны Ганхуяг 65,951 ширхэг санал;

Чулууны Ганзориг 65,402 ширхэг санал;

Чулуунбаатарын Хандаа 65,382 ширхэг санал;

Ганзоригийн Мягмаржав 65,382 ширхэг санал;
Батбилэгийн Золбоо 65,402 ширхэг санал;
Баярмагнайн Гантиг 65,387 ширхэг санал;

Хараат бус гишүүд;
Энхриймаагийн Хасар 65,392 ширхэг санал;
Алтангэрэлийн Тулга 65,392 ширхэг санал;
Цэрэнгалсангийн Энх-Амгалан 65,387 ширхэг санал;

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Нэгж эрх эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

1. Булган-Ундарга ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
2. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ч.Ганхуяг, Б.Золбоо, Ч.Хандаа, Г.Мягмаржав, Ч.Ганзориг, Б.Гантиг нар сонгогдов. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Э.Хасар, А.Тулга, Ц.Энх-Амгалан нар сонгогдов.
3. Компанийн бүртгэлтэй хаягийн өөрчлөлтийг батлав.
4. Компанийн дүрмийн шинэчлэгдсэн найруулгыг батлав.

Хурал 12 цаг 40 минутанд дуусав.

ХЯНАСАН:
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Ч.ГАНХУЯГ

Б.ОЮУНСУВД